

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХААХОУС	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
ДДБОС	Даян дэлхийн байгаль хамгаалах сан
БУУАӨДЗ	Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох
БАМБ	Бэлчээр ашиглагч малчдын бүлэг

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3.Аудитын тайлан	14
3.1. Ерөнхий зүйл	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал.....	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт	19
Залруулсан алдаа.....	19
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	20
4. Менежментийн захидал.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	23



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАХ ЗЭЭЛ БА БЭЛЧЭЭРИЙН
УДИРДЛАГЫН ХӨГЖИЛ ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ С.ЗАНДАНБАЛ
ТАНАА

2021.02.25 № 04/533
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх Олон улсын сангийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжин хэрэгжиж буй Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн зарцуулалтын тайланд аудит хийлээ.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн зарцуулалт материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 94,5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>8,517,514,556.14</u>	<u>11,852,221,297.48</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	<u>8,483,664,614.58</u>	<u>11,801,173,284.18</u>
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	1,909.16	0.00
31110	Төгрөг	1,909.16	0.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,483,662,705.42	11,801,173,284.17
3121	Төгрөг	4,606,424,133.15	7,053,324,851.29
31211	Төрийн сангийн харилцах	4,606,424,133.15	3,914,954,174.61
31213	Арилжааны банк дахь харилцах	-	3,138,370,676.68
3122	Гадаад валют	3,877,238,572.27	4,747,848,432.89
31223	Арилжааны банк дахь харилцах	3,877,238,572.27	4,747,848,432.89
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	<u>27,658,461.56</u>	<u>51,048,013.30</u>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	31,814.00	394,046.59
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	4,702,059.56	-
335	Бусад авлага	22,924,588.00	50,653,966.71
3351	Байгууллагаас авах авлага	22,924,588.00	50,653,966.71
34	УРЬДЧИЛГАА	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	<u>6,191,480.00</u>	-
354	Хангамжийн материал	6,191,480.00	-
35420	Аж ахуйн материал	5,791,680.00	-
35470	Бусад хангамжийн материал	399,800.00	-
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>733,798,536.95</u>	<u>645,573,302.49</u>
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>733,798,536.95</u>	<u>645,573,302.49</u>
392	Биет хөрөнгө	<u>733,798,536.95</u>	<u>644,767,746.95</u>
39203	Авто-тээврийн хэрэгсэл	422,900,000.00	422,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	- 122,220,833.38	- 164,510,833.42
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	205,529,440.00	210,500,745.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	- 46,860,147.98	- 94,413,840.62
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	86,778,604.00	92,490,094.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	- 9,978,525.69	- 19,848,418.01
39214	Бусад үндсэн хөрөнгө	197,650,000.00	197,650,000.00
393	Биет бус хөрөнгө	-	<u>805,555.54</u>
39301	Програм хангамж	-	1,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	- 194,444.46
394	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>9,251,313,093.09</u>	<u>12,497,794,599.97</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>3,722,651,535.00</u>	<u>4,124,971,050.98</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	<u>3,722,651,535.00</u>	<u>4,124,971,050.98</u>
412	Богино хугацаат зээлийн өглөг	-	<u>365,570,676.68</u>

4121	Төгрөг	-	365,570,676.68
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	-	365,570,676.68
413	Өглөг	345,051,535.00	381,800,374.30
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	63,000.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,120,290.00	4,604,655.00
4136	Бусад өглөг	332,931,245.00	377,132,719.30
41361	Байгууллагад төлөх өглөг	332,666,637.00	377,097,508.30
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	264,608.00	35,211.00
414	Урьдчилж орсон орлого	3,377,600,000.00	3,377,600,000.00
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	3,377,600,000.00	3,377,600,000.00
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>5,528,661,558.09</u>	<u>8,372,823,548.99</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	5,528,661,558.09	8,372,823,548.99
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
51101	Өмч: - төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	5,528,661,558.09	8,372,823,548.99
51210	Өмнөх үеийн үр дүн	5,528,661,558.09	5,528,661,558.09
51220	Тайлант үеийн үр дүн	-	2,844,161,990.90
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>9,251,313,093.09</u>	<u>12,497,794,599.97</u>

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,507,707,807.88	8,365,136,863.06
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,188,587,807.88	8,086,551,163.06
120	Нийтлэг татварын бус орлого	4,188,587,807.88	8,086,551,163.06
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,185,669,854.88	7,994,763,550.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	281,428,209.24	479,961,087.40
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,904,241,645.64	7,514,802,463.40
120009	Бусад орлого	2,917,953.00	91,787,612.26
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	319,120,000.00	278,585,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	319,120,000.00	278,585,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	319,120,000.00	278,585,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,688,929,072.76	5,694,564,636.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,151,365,063.76	1,938,910,175.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,774,035,997.34	1,885,207,483.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	898,274,833.00	481,290,801.00
210101	Үндсэн цалин	898,274,833.00	481,290,801.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	110,679,883.00	59,608,579.00
210201	Тэтгэврийн даатгал	76,513,360.00	59,608,579.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,982,748.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,186,198.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	1,636,143.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	16,361,434.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,276,786.02	103,434,004.49
210301	Гэрэл, цахилгаан	195,799.99	681,354.60
210303	Цэвэр, бохир ус	36,186.48	-
210304	Байрны түрээс	78,044,799.55	102,752,649.89
2104	Хангамж, бараа материалын зардал	27,252,756.51	53,440,905.14
210401	Бичиг хэрэг	5,052,803.00	6,536,477.81
210402	Тээвэр, шатахуун	8,868,272.89	22,742,450.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,130,817.62	5,879,153.83
210404	Ном, хэвлэл	-	8,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,200,863.00	10,282,823.30
2107	Томилолт, зочны зардал	29,929,750.00	42,189,440.00
210702	Дотоод албан томилолт	29,929,750.00	42,189,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,121,840,043.70	1,044,568,936.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,121,840,043.70	1,044,558,936.69
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	10,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	507,781,945.11	100,674,817.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	466,880,861.29	766,788.17
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	40,901,083.82	99,908,029.46
211	ХҮҮ	-	-

212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	377,329,066.42	53,702,692.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,447,852.04	43,952,181.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,525,004.60	20,381,787.46
213304	Хөрөнгийн	8,922,847.44	23,570,394.19
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	301,881,214.38	9,750,510.35
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	301,881,214.38	9,750,510.35
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,537,564,009.00	3,755,654,460.32
2200	Дотоод эх үүсвэрээр	1,537,564,009.00	3,755,654,460.32
220001	Барилга байгууламж	896,568,250.00	3,322,901,565.02
221001	Их засвар	456,692,492.00	366,795,701.80
222001	Тоног төхөөрөмж	184,303,267.00	65,957,193.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-1,181,221,264.88</u>	<u>2,670,572,226.79</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	162,284,229.35	173,589,764.11
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	162,284,229.35	173,589,764.11
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	38,907,038.10	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	38,907,038.10	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	123,377,191.25	173,589,764.11
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>- 1,057,844,073.63</u>	<u>2,844,161,990.90</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	7,791,295,419.26	8,635,030,406.75
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,996,827,344.16	8,356,444,706.75
120	Нийтлэг татварын бус орлого	3,996,827,344.16	8,356,444,706.75
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,996,616,069.16	8,340,205,706.75
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	92,374,423.52	88,244,935.75
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,904,241,645.64	7,514,802,463.40
1200047	Түрээсийн орлого		737,158,307.59
120009	Бусад орлого	211,275.00	16,239,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,794,468,075.10	278,585,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,794,468,075.10	278,585,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	319,120,000.00	278,585,700.00
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,475,348,075.10	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,005,675,700.99	2,232,209,728.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,005,675,700.99	2,232,209,728.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,628,346,634.57	1,806,919,405.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	443,129,859.00
210101	Үндсэн цалин	-	443,129,859.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	59,915,440.00
210201	Тэтгэврийн даатгал	-	59,915,440.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,857,078.19	95,026,845.00
210301	Гэрэл, цахилгаан	178,000.00	619,413.29
210303	Цэвэр, бохир ус	32,896.80	-
210304	Байрны түрээс	71,646,181.39	94,407,431.72
2104	Хангамж, бараа материалын зардал	25,650,160.62	50,957,313.22
210401	Бичиг хэрэг	4,970,401.00	5,998,114.00
210402	Тээвэр, шатахуун	7,933,900.00	22,072,561.09
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,008,838.62	5,378,820.77
210404	Ном, хэвлэл	-	8,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,737,021.00	9,507,817.36
2107	Томилолт, зочны зардал	29,929,750.00	42,189,440.00
210702	Дотоод албан томилолт	29,929,750.00	42,189,440.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,034,028,784.47	1,114,722,445.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,034,028,784.47	1,114,712,445.33
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	10,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	466,880,861.29	978,063.17
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	466,880,861.29	978,063.17
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	-	-

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	377,329,066.42	425,290,322.91
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	75,447,852.04	43,952,181.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,525,004.60	20,381,787.46
213304	Хөрөнгийн	8,922,847.44	23,570,394.19
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	301,881,214.38	381,338,141.26
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	301,881,214.38	381,338,141.26
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3,785,619,718.27</u>	<u>6,402,820,678.11</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,303,960,717.00	3,258,901,772.65
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,303,960,717.00	3,258,901,772.65
2200	Дотоод эх үүсвэрээр	1,303,960,717.00	3,258,901,772.65
220001	Барилга байгууламж	577,010,025.00	2,840,429,253.65
221001	Их засвар	396,615,584.00	353,428,420.00
222001	Тоног төхөөрөмж	330,335,108.00	59,961,085.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	5,083,014.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-1,303,960,717.00</u>	<u>-3,258,901,772.65</u>
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-123,377,191.25	-173,589,764.10
250001	Гадаад валютын ханшийн зөрүү	- 123,377,191.25	-173,589,764.10
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>123,377,191.25</u>	<u>173,589,764.10</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	2,605,036,192.52	3,317,508,669.56
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,878,628,422.06	8,483,664,614.58
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,483,664,614.58	11,801,173,284.13

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	6,586,505,631.72	6,586,505,631.72
Тайлант үеийн үр дүн	-	- 1,057,844,073.63	- 1,057,844,073.63
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	5,528,661,558.09	5,528,661,558.09
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	61,206,698.50	61,206,698.50
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	5,589,868,256.59	5,589,868,256.59
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-61,206,698.50	-61,206,698.50
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	2,844,161,990.90	2,844,161,990.90
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	8,372,823,548.99	8,372,823,548.99

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланТайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		8,483,664,614.58	-	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,207,127,200.00	7,837,633,115.21	2,369,494,084.79	76.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,839,327,200.00	1,806,931,342.55	32,395,857.45	98.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,839,327,200.00	1,806,931,342.55	32,395,857.45	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	443,130,000.00	443,129,859.00	141.00	100.0
210101	Үндсэн цалин	443,130,000.00	443,129,859.00	141.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,915,900.00	59,915,440.00	460.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	59,915,900.00	59,915,440.00	460.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	101,193,300.00	95,026,845.00	6,166,455.00	93.9
210301	Гэрэл, цахилгаан	620,000.00	619,413.29	586.71	99.9
210304	Байрны түрээс	100,573,300.00	94,407,431.72	6,165,868.28	93.9
2104	Хангамж, бараа материалын зардал	51,650,000.00	50,957,313.22	692,686.78	98.7
210401	Бичиг хэрэг	6,398,600.00	5,998,114.00	400,486.00	93.7
210402	Тээвэр, шатахуун	22,363,300.00	22,072,561.09	290,738.91	98.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,378,900.00	5,378,820.77	79.23	100.0
210404	Ном, хэвлэл	8,000,000.00	8,000,000.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,509,200.00	9,507,817.36	1,382.64	100.0
2105	Нормативт зардал	-	-	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-	-	-
2107	Томилолт, зочны зардал	44,689,400.00	42,189,440.00	2,499,960.00	94.4
210702	Дотоод албан томилолт	44,689,400.00	42,189,440.00	2,499,960.00	94.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,138,748,600.00	1,115,712,445.33	23,036,154.67	98.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,138,748,600.00	1,115,712,445.33	23,036,154.67	98.0
211	ХҮҮ	-	-	-	-
212	ТАТААС	-	-	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,785,000,000.00	3,257,901,772.65	1,527,098,227.35	68.1
2200	Дотоод эх үүсвэрээр	4,785,000,000.00	3,257,901,772.65	1,527,098,227.35	68.1
220001	Барилга байгууламж	4,310,000,000.00	2,840,429,253.65	1,469,570,746.35	65.9
221001	Их засвар	390,000,000.00	353,428,420.00	36,571,580.00	90.6
222001	Тоног төхөөрөмж	85,000,000.00	64,044,099.00	20,955,901.00	75.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	3,582,800,000.00	2,772,800,000.00	810,000,000.00	77.4
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	3,582,800,000.00	2,772,800,000.00	810,000,000.00	77.4

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,207,127,200.00	7,837,633,115.21	2,369,494,084.79	76.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	278,585,700.00	258,203,912.54	20,381,787.46	92.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	278,585,700.00	258,203,912.54	20,381,787.46	92.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	9,928,541,500.00	7,579,429,202.67	2,349,112,297.33	76.3
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	9,928,541,500.00	7,579,429,202.67	2,349,112,297.33	76.3
122	ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ	-	-	-	-
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8,483,664,614.58	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	11,801,173,284.13	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	57	57	-	100.0
620001	Удирдах ажилтан	2	2	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	50	50	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2	-	100.0
620004	Гэрээт ажилтан	3	3	-	100.0

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг төслийн зохицуулагч С.Занданбал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн программыг сайжруулах, анхан шатны баримтын бүрдэл дээр бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хүрээнд авлага, өглөг үүсгэхгүй байх, хөрөнгийн ангиллыг зөв хийх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын захиалгаар “Ажу мэргэн аудит” ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Насанбуян, чанарын хяналтын менежер Л.Долгорсүрэн нар удирдан аудитор Д.Наранчимэг туслах аудитор С.Сарантуяа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 11/21 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төсөл, хөтөлбөрийн зорилго: Хөдөөгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх, амьжиргааг тогтвортой дээшлүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар болон Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан (ХААХОУС) /IFAD/-аас тавьсан зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх явдал юм.

Тус төслийн үйл ажиллагааны чиглэл нь Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Монгол мал хөтөлбөр”, “Хоршоог хөгжүүлэх хөтөлбөр”, “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөр”-т нийцүүлэн төсөл хэрэгжиж буй аймгуудын малчин өрх болон аймаг, сумын төвийн иргэдийн амьжиргааг дээшлүүлж, ядуурлыг бууруулах зорилгоор жижиг дунд үйлдвэр, хоршоог дэмжиж ажлын байрыг нэмэгдүүлэх, нэмүү өртгийг бий болгоход оршино.

- Тус төсөл нь .
1. Зах зээлийн хөгжил
 2. Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь
 3. Төслийн менежмент гэсэн 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Тайлант хугацаанд хийсэн ажлын талаар: Төслийн хүрээнд байгуулагдсан 144 малчны бүлэг, 250 эмэгтэйчүүдийн давамгайлсан бүлгүүдийг чадавхжуулах сургалтууд болон мал аж ахуйн үйлдвэрлэл, бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр сумын түвшинд хөрөнгө оруулалтууд хийгдсэн байна.

Гэрээт төрийн бус байгууллагуудаар дамжуулан бүлгийн гишүүдэд хийгдэх нийт 8 төрлийн сургалтыг танхимаар болон цахимаар хэрэгжүүлсэн ба Ковид-19 цар тахлын

шалтгаанаар хөл хорио тогтоосны улмаас бусад танхимын болон талбайн сургалтууд, гадаад дотоод туршлага судлах арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. 2020 онд сургалт ангиллаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийн биелэлт 9 хувьтай байна.

6 аймгийн сонгогдсон 24 суманд хөрөнгө оруулалт хэрэгжихээр заасан боловч 2020 онд төслийн хэрэгжилтийн үр ашиг, тогтвортой байдлыг хангах үүднээс сумдын тоог нэмэгдүүлж 98 суманд орон нутгийн хамтарсан санхүүжилтээр дараах хөрөнгө оруулалтын ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

. Үүнд:

№	Хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлууд	2020 оны Хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт		
		Төлөв	Гүйц.	Тайлбар
1	Тэжээлийн агуулах, өвсний саравч шинээр барих	11	100	Бүрэн хэрэгжсэн.
2	Тэжээлийн агуулах, өвсний саравч засварлах	10	100	Бүрэн хэрэгжсэн.
3	Гүн өрмийн худаг	157	94	Дундговь аймагт 9 худаг шинээр гаргах нэг багц ажлын гэрээ цуцлагдсан. (гэрээ байгуулсан компани тодорхой шалтгааны улмаас ажил гүйцэтгэх боломжгүй болсон)
4	Бог мал угаалгын суурин банн	87	78	Хэнтий, Сүхбаатар аймагт банн барих тус бүр нэг гэрээ (нийт 19 банн) цар тахлын улмаас хугацаандаа дуусгаж чадалгүй гэрээг сунгасан. (компани импортоор хашаа авахаар байсан)
5	Борлуулалтын цэг шинээр барих	7	85	Сүхбаатар аймагт шинээр барихаар төлөвлөсөн борлуулалтын цэг газрын маргааны улмаас баригдаагүй.
6	Борлуулалтын цэг/ажлын байр засварлах	4	100	Бүрэн хэрэгжсэн.
	Дундаж		92.8	

Төслийн хүрээнд хэрэгжсэн дээрх хөрөнгө оруулалтын ажлуудын санхүүжилт, худалдан авалтыг зохион байгуулах, ажлын гүйцэтгэлд хяналт тавих, талуудын хүлээх үүрэг хариуцлагыг зохицуулах, “ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ”-г төсөл хэрэгжүүлэх 6 аймгийн Засаг дарга болон ХХААХҮСайдын хооронд байгуулан, хамтран ажилласнаар нийт хөрөнгө оруулалтын ажил 92.8 хувиар хэрэгжсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн удирдлага санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн нэгж ХХААХҮЯ-наас 2019 онд баталсан Хөдөө аж ахуйн салбарт мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрддөг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүнс, Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд төслийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн. Дотоод аудитаар 14 асуудлын хүрээнд үйл ажиллагаанд оршиж байгаа алдаа зөрчлийг илрүүлж зөвлөмж өгсөн байна. ХХААХҮЯ-ны дотоод аудитын хорооны 01 дугаар тогтоолоор зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.

ХХААХҮЯ-ны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд үр “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзжээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,727,836.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 57,278.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд суурь үзүүлэлт, хувь хэмжээг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллын байдлын түвшинг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 5,694,564.6 мянган төгрөгийн 1 хувиар тооцож 56,945.6 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,246,481.5 мянган төгрөгөөр буюу 35.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,483,664.6	11,801,173.3	3,317,508.7
Авлага	27,658.4	51,048.0	23,389.5
Бараа материал	6,191.5	0	-6191.5
Үндсэн хөрөнгө	733,798.5	645,573.3	-88,225.2
Нийт хөрөнгө	9,251,313.1	12,497,794.6	3,246,481.5
Өр төлбөр	3,722,651.5	4,124,971.0	402,319.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	5,528,661.5	8,372,823.5	2,844,162.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,251,313.1	12,497,794.6	3,246,481.5

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан данс байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 11,801,173.3 мянган төгрөг болж 3,317,508.7 мянган төгрөгөөр өссөн нь зээлийн батлан даалтын хөрөнгийн Хаан банкинд хадгаламж хэлбэрээр байршуулсан, дамжуулан зээлийн өглөгийг бүртгэсэн нь арилжааны банк дах төгрөгийн харилцах дансны үлдэгдлийг 3,138,370.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ. Энэ нь төслийн хамрах хүрээ өргөжсөнтэй холбоотойгоор зээлийн хөрөнгийн ашиглалт өмнөх жилээс 3,610,560.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Авлага дансны үлдэгдэл 51,048.0 мянган төгрөг болж 23,389.5 мянган төгрөгөөр өссөн нь батлан даалтын хөрөнгө байршуулсны хүүгийн орлого 34,944.8 мянган төгрөг тухайн тайлант онд орж ирээгүйгээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд түрээсийн барьцаа хөрөнгө байршуулсны 15,709.0 мянган төгрөг, цалин, ХХОАТ-тай холбоотой 394.0 мянган төгрөгийн авлагууд багтсан байна.

Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6,191.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх жилийн аудитын зөвлөмжөөр үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг эргэлтийн хөрөнгөөр бүртгэсэн байна гэж зөвлөмж өгсний дагуу залруулж бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 88,225.2 мянган төгрөгөөр буурсан нь 5,971.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, санхүүгийн программ худалдан авч 99,713.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 4,124,971.0 мянган төгрөг болж 402,319.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хүлээн авсан гэрээт ажлын төлбөр, мөн дамжуулан зээлийн өглөг 365,570.6 мянган төгрөгөөр бүртгэснээс шалтгаалжээ. Үүнд: Сойл инженеринг ХХК-д өгөх 158,474.9 мянган төгрөг, Сагсай өргөө ХХК-д өгөх 154,826.2 мянган төгрөг, Жорон ХХК-д 13,922.4 мянган төгрөгийн өглөг байна.

Урьдчилж орсон орлого 3,377,600.0 мянган төгрөг нь батлан даалтын хөрөнгө байршуулснаас үүссэн өр төлбөр байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,372,823.5 мянган төгрөг болж 2,844,162.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 3,857,429.0 мянган төгрөгөөр буюу 85.5 хувиар өссөн байна.

Дансны үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилтын орлого буурсан нь Ковид-19 цар тахлын улмаас арилжааны банкууд 2020 оны 05 дугаар сараас эхлэн дансны үлдэгдэлд хүү бодоогүй, зээлийн батлан даалтын дэд нэгжийн урсгал зардлын төсвийг өмнөх оноос 40,534.3 мянган төгрөгөөр бууруулж баталснаас шалтгаалсан байна. Зарцуулаагүй төсвийн үлдэгдэл 20,381.8 мянган төгрөгийг улсын төсвийн орлогод татан төвлөрүүлсэн байна.

Нийт зардал өмнөх оноос 5,635,6 мянган төгрөгөөр буюу 0,9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь хөрөнгийн зардал 2,218,090.5 мянган төгрөгөөр өссөн. Энэ нь тайлант онд төслийн хэрэгжилтийн үр ашиг, тогтвортой байдлыг хангах үүднээс сумдын тоог нэмэгдүүлж 98 суманд бодит хөрөнгө оруулалтын ажлуудыг хэрэгжүүлснээр хөрөнгийн зардал өссөн,

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан 61,206.7 мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн залруулга нь өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитын зөвлөмжийн дагуу “Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө” УСНББОУС-4 стандартын дагуу орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй ханшийн зөрүүгийн олзыг залруулга хийн тайлагнаснаас шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус төслийн 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 10,797,500.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 10,797,500.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2020 оны 10-р сард Ковид-19 цар тахлын улмаас 590,372.8 мянган төгрөгөөр бууруулж 10,207,127.2 мянган төгрөгөөр баталсан байна. Тайлант оны төсөв өмнөх оны баталсан төсвөөс 5,080.8 мянган төгрөгөөр илүү баталсан нь санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу төсөл хэрэгжих хугацаа 2021 оны 09 сарын 30-д дуусахтай холбоотойгоор санхүүжүүлэгч байгууллагаас хөрөнгө оруулалтын гол ажлуудыг тайлант онд багтаан хэрэгжүүлэх шийдвэр гаргаснаас шалгаалжээ. Ковид-19 цар тахлын улмаас төсөл хэрэгжих хугацааг 2020 оны 4 дүгээр сард Хөдөө аж ахуйг хөгжүүлэх Олон улсын сан болон Сангийн яам нэг жилээр сунгах шийдвэр гаргасан байна.

Тайлант онд төсвийн захирагчийн, гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил үйлчилгээ хөтөлбөр, төслийн дотоод урсгал зардал гэсэн хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд зориулан 10,207,127.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас Нэгдсэн үндэстний байгууллагын ХААХОУС-ийн хөнгөлөлттэй зээлээр 9,928,541.5 мянган төгрөг, 278,585.7 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 278,585.7 мянган төгрөг, зээлийн хөрөнгөнөөс 7,514,802.5 үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 753,397.3, нийт 8,635,030.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,806,931.3 мянган төгрөг, зарцуулж, хөрөнгийн зардалд 3,257,901.8 мянган төгрөг Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл 2,772,800.00 мянган төгрөг, нийт 7,837,633.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

“Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” нэмэлт санхүүжилт төсөл нь 2020 онд Зээлийн хөрөнгөнөөс 7,514,802.4 мянган төгрөг зарцуулсан байна. Энэхүү эх үүсвэрээс ажил ангиллаар 3,210,910.4 мянган төгрөг, зээл, батлан даалтын сангийн ангиллаар 2,772,800.0 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээ болон орц ангиллаар 1,043,772.5 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 473,807.8 мянган төгрөг, сургалтын зардалд 78,138.5 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил үйлчилгээ хөтөлбөр 2,349,112.3 мянган төгрөгөөр, хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал хөтөлбөр 20,381.8 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 395 мэдээллээс 305-ыг хугацаанд нь оруулсан, 50 мэдээллийг хугацаа хоцроосон бол 40 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, давтан гаргахгүй байх 71,665.9 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 296,712.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 285,757.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 10,955.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Харилцах дансны хооронд хийгдэх 4,000.0 мянган төгрөг, тохируулга бичилт хийхтэй холбоотой бүртгэлийн алдаа гарсан 21.0 мянган төгрөг, нийт дүнгээр мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 3,979.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.
2. Ажлын гүйцэтгэл нь бүрэн хийгдсэн ажил гүйлгээг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй, авлагын дансыг хааж бүртгээгүй байсныг залруулав.
3. Биет бус хөрөнгийн чанартай 1,000.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байсныг биет бус хөрөнгөд, 194.5 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг бүртгэж залруулав.
4. Гэрээт ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлэхэд суутгасан НӨАТ-ын 10 хувь 62,400.9 мянган төгрөгийг НӨАТ-ын орлогоор бүртгээгүй байсныг залруулав.
5. Төслийн хүрээнд хийгдсэн гэрээт ажлыг хүлээн авсан актын дагуу 210,476.9 мянган төгрөгийг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч өглөг үүсгээгүй, гэрээт ажлуудыг хугацаандаа хийж гүйцэтгээгүй алданги торгуулийн орлого 84,399.7 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 395 мэдээллээс 305-ыг хугацаанд нь, 50 мэдээллийг хугацаа хоцроосон, 40 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулах, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 10,955.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав. Үүнд:

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Иргэнээс авто машины зогсоол түрээсэлж 10,955.2 мянган төгрөгийн түрээсийн төлбөр өгсөн байна. Энэ нь хэрэглэгчийн нэгдсэн системд бүртгэгдсэн төлбөрийн баримтгүйгээр санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, холбогдох хууль тогтоомжууд, Сангийн сайдын тушаалаар батлагдсан журам, зааврыг хэрэгжүүлээгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Холбогдох хуулийн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан хэрэглэгчийн системд бүртгэгдсэн төлбөрийн баримтаар баталгаажуулан анхан шатны баримтын бүрдлийг ханган нягтлан бодох бүртгэлд тусгаж байх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг биелүүлж ажиллана, алдааг давтан гаргахгүй.

2 . Нягтлан бодох бүртгэлийн программын талаар

2.1 Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн программын сайжруулалт, тохируулга дутуу хийгдсэнээс нягтлан бодох бүртгэлийн хураангуй ба дэлгэрэнгүй журнал, тодруулга тайлангийн дүнгүүд хоорондоо зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 тоот тушаалын 1-р хавсралт “Аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ыг хангахгүй байна.

2.2 Эрсдэл:

Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулалт алдаатай хийгдэх, тохируулга гүйлгээ буруу хийгдсэнээс ажил гүйлгээ орхигдох, тайлан буруу илэрхийлэгдэх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлагад нийцүүлэн тохиргоо, сайжруулалт хийлгэх.

2.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

“Хас эрин орчил” ХХК-ийн Динамик ONLINE программыг шинээр суурилуулан эхний удаа тайлан гаргаж байгаа тул зарим тохируулгыг нэмж хийлгэх шаардлагатай байна.

Программд тавих шаардлагыг хангуулж сайжруулалт хийлгэх талаар хүсэлтээ хүргүүлээд байгаа.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад хийсэн аудит	Аудитын код:
20..			САГ-2021/31/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:	Ажу мэргэн аудит ХХК		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Авто машины зогсоол түрээслэж 10,955.2 мянган төгрөгийн түрээсийн төлбөр өгсөн. Эдгээр иргэдийн түрээсийн төлбөрөөс ХХОАТ суутгах эсвэл хэрэглэгчийн нэгдсэн системд бүртгэгдсэн төлбөрийн баримт авалгүй санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэсэн.	10,955.2	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Уламбаяр
2	Нягтлан бодох бүртгэлийн програмын сайжруулалт, тохируулга дутуу хийгдсэнээс нягтлан бодох бүртгэлийн хураангуй ба дэлгэрэнгүй журнал, тодруулга тайлангийн дүнгүүд хоорондоо зөрүүтэй байна.	0	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Б.Уламбаяр
3	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллэвэл зохих цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 143 гүйлгээнээс 103 гүйлгээг мэдээллэж 40 гүйлгээг мэдээллээгүй байна	0	Албан шаардлага өгөх	Нягтлан бодогч	Б.Уламбаяр
ДҮН		10,955.2			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 117/АД160063

Улаанбаатар хот

САГ-2021/31/СТА-ТХН
Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын цахим хуудсанд оруулбал зохих 395 мэдээллээс хугацаа хоцроосон 50 мэдээлэл, мөн 40 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр," гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг төслийн зохицуулагч С.Занданбал, нягтлан бодогч Б.Уламбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
"АЖУ МЭРГЭН АУДИТ" ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭРДЭНЭЗУЛ

Л.НАСАНБУЯН

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 28 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for letter height. The entire page is otherwise blank, with no margins, text, or other markings.

[illegible]

[illegible]